

Соёл урлагийг дэмжих сангийн 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилт

“Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийн хүрээнд Соёл урлагийг дэмжих сангаас 2022 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг 2022.04.18 - 2022.05.06 - ны өдрүүдэд Соёл урлагийг дэмжих сангийн цахим системээр хүлээн авсан бөгөөд нийт 336 төсөл, арга хэмжээ цахим системд бүртгэгдсэн.

Соёлын сайдын 2022 оны А/157 дугаар тушаалаар байгуулагдсан сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан 06 дугаар сарын 03 – 05 ний өдрүүдэд зохион байгуулагдаж цахим системд бүртгэгдсэн нийт төсөлд үнэлгээ өгөх эхний шатны шалгаруулалтыг (а) Төсөлд үнэлгээ хийх боломжтой эсэх, (b) төслийн иж бүрдлийн үнэлгээ (c) төсөлд тавигдах шаардлага, төслийн ач холбогдлын үнэлгээ гэсэн гурван шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэж нийт 90 төсөл, арга хэмжээг дараагийн шатны шалгаруулалтад дэмжихээр шийдвэрлэсэн. Ажлын хэсгийг хуралдаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын холбогдох мэргэжилтнүүд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан.

Дараагийн шатны шалгаруулалтыг угтаж шалгарсан 90 төслийн багийн гишүүдэд 2022 оны 06 дугаар сарын 12 - ны өдөр МҮХАҮТ – ын хурлын зааланд төслийн боловсруулалт үр дүнг, танилцуулахтай холбоотой сургалтыг зохион байгуулж 122 хүнийг хамруулсан.

Соёл урлагийг дэмжих сангийн төслийн сүүлийн шатны шалгаруулалтыг 06 дугаар сарын 17 – 19 - ний өдрүүдэд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн (600 студи) байранд зохион байгуулж уг шалгаруулалтад нийт 90 төслийн багийн гишүүд ажлын хэсгийн гишүүдэд төслөө танилцуулсан бөгөөд уг төслийн шалгаруулалтыг “Монгол соёл – Монголын баялаг” нэртэйгээр тус бүр 40 минутын нийт 10 цуврал нэвтрүүлэг болгож МҮОНТ - ээр үзэгчдийн хүртээл болсон.

Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нь сүүлийн шатны шалгаруулалтад оролцсон нийт 90 төслөөс сонгон шалгаруулалт хийх хуралдаан зохион байгуулж 2022 онд тус сангаас санхүүжүүлэх төслүүдийг тодорхойлж дүгнэлтийг “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.6 -д заасны дагуу Соёлын сайдад танилцуулж Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаар тушаалаар “Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, санхүүжилт батлах тухай” тушаалаар 1,409,300,000 /нэг сая дөрвөн зуун есөн мянга гурван зуу/ төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гарсан.

Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлсэн төслийн мэдээлэл

	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжилт авсан харилцагч
1	Ардын дууны өв санг хүүхдийн төрөлд баяжуулах "Үрс" телеконцерт төсөл	Баатар овогтой Эрдэнэбат
2	Монгол хүүхдийн Гэр сургалт	Болдбаатар овогтой Энхсаруул
3	"Эгэл" Монгол өв соёлын мултимедиа контент бүтээх төсөл	Пүрвээ овогтой Баттулга
4	"Цаг хугацааны мөнх бус руу инээмсэглэгсэд" роман	Дамдинсүрэн овогтой Урианхай
5	Монголчуудын аман түүхийн судалгаа	Тамиржав овогтой Билэгсайхан
6	"Нүүдлийн урлан" орон нутаг дахь гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих санаачилга	Циен-Ойдов овогтой Батсайхан
7	"Монгол тайлбартай брайль нот"	"Монголын тахир дутуу иргэдийн увдас сэтгэл зүйн төв" НҮТББ, 1029584,
8	Чимээгүй театр /сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан 2 хүний драмын жүжгийн төсөл/	"Шинэ үеийн нэгдмэл залуус" НҮТББ (Регистрийн дугаар: 8200726,
9	"Walking culture- Түүх соёлын жим 2022" соёлын танин мэдэхүйн зорилтот төсөл	"Монголын явган алхалтын холбоо" ХХК, 8309973,
10	Сөөсгөр хүүхэлдэйн жүжиг	"Эрдэнэт соёл урлаг" НҮТББ, 8129401
11	Мөнх Тунх Монгол бичгийг аварсан нь	"Гэртүүн" ХХК, 6560997
12	"Арухай хүү" танин мэдэхүйн комик цуврал	"Энхтэгш" ХХК, 5787815
13	Харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад зориулсан ардын аман зохиолын эмхтгэл хийж тэдэнд хүртээмжтэй хэлбэрээр хэвлэж сурталчлан таниулах	"Монголын хараагүйчүүдийн холбоо" ГҮТББ, 1010964
14	"Онцгой авъяастан" хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг уран зургаар хөгжүүлэх	"Онцгой авъяастан урлагаар хөгжүүлэх боловсролын төв" НҮТББ, 6538991
15	Монголын үндэсний өсвөр болон залуу хөгжимчдийн "Гэрэгэ" улсын анхдугаар /нээлттэй/ уралдаан	"Монгол үндэсний хөгжим хөгжимчдийн холбоо" НҮТББ, 1047299
16	Хорвоотой танилцсан түүх	"Театр стил" ХХК, 6541283
17	"Өв соёл", "Цээрлэх ёс"	"Өсөх ирээдүй холбоо" НҮТББ, 1026925
18	"Жонон харын домог" хүүхэд, гэр бүлд зориулсан шинжлэх ухааны тайлбар бүхий зурагт ном	"Монголын нууц товчоог дэлхийд түгээе" сан, 8182027
19	"Элбэс ширэг" төсөл: Эх амаржих, хүүхэд өсгөхтэй холбогдсон Монгол домын соёлыг баримтжуулж, цахим контентоор дамжуулан сурталчлах	"Цахим суварга соёлын өвийн эрэл хайгуулчид" НҮТББ, 6721664,
20	Үлгэр домог, өв соёл	"Соёл урлаг хэвлэл мэдээллийн менежмент зөвлөгөө" НҮТББ, 8192731,
21	Сониуч хүүгийн адал явдал	"Саунд ов фильм"ХХК, 3683079

22	Соёлын өвийн дурсгал хүүхдийн нүдээр	Монголын үзэсгэлэнт байгаль түүхэн дурсгалт газрууд НҮТББ, 6757138
23	Амьтны цирк Монголд	“Уран нугаралтыг хөгжүүлэх шинэ цирк төв” НҮТББ, 1067036,
24	“Гюүг метаверст Өв соёлын төв ордон байгуулах нь” төсөл	Гарааны дижитал солюшнс” ХХК, 6426441
25	"Монголын хөгжмийн зохиолчдын намтар судлал, бүтээлийн өв" цуврал монограф, гар бичмэл баримтат өвийг хамгаалах төсөл	“Монгол улсын консерватори” ХХК, 9087249
26	"Монголын хувцас дизайн урлал, экспортод чиглэсэн онцгой бүтээлийг гадаад оронд сурталчлан таниулах төсөл	“Зосон фэшн” ХХК, 6138829
27	Төв орон нутгийн Ардын дуу бүжгийн чуулгуудын шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах 2022 төсөл	“Монголын урлагийн ажилтны холбоо” НҮТББ, 102569
28	Дэлхийн өвийн дурсгалт газрын уур амьсгалын судалгаа, түүнд соёлын өвийн өртөх байдал” сэдэвт судалгааны ажил хийх	“Далай өлзий” НҮТББ, 8270333
29	Сэцэн хан аймгийн биет бус соёлын өв	Соёл шинжлэх ухаан судлалын хөгжил үндэсний төв ТББ, 64999384
30	Археологийн малтлагаар илэрсэн модон эдлэлийг сахарын уусмалын аргаар бэхжүүлэх, насжилтыг уртасгах	“Хархорум музей” төрийн байгууллага, 5310717
31	Соёлын биет бус өвийн цахим музей байгуулах	“Бидний бүрэн монгол” НҮТББ, 6717241